


ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2022 ОНЫ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН


2022 оны 12 дугаар сарын 25-ны өдөр



Сайншанд хот

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	<p>“Хүнс хөдөө аж ахуйн газрын do.mofa.gov.mn вэб сайт, Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газар, ХХААГ-ын facebook хуудас, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж салбарын бодлого, ХХААГ-ын үйл ажиллагааг сурталчлах, санхүүгийн мэдээллийг сар бүр мэдээллийн самбарт байршуулан байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгон ажилласан. Хөдөө аж ахуйн салбарын төр засгаас болон орон нутгаас зохион байгуулж буй арга хэмжээ болон мэдээ мэдээллийг олон нийтэд шуурхай хүргэн ажилласнаар байгууллагын веб сайтад жилийн эцсийн байдлаар нийт 129 мэдээллийг оруулж давхардсан тоогоор 3352 иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг ханган ажилласан. Байгууллагын гадна мэдээллийн самбарт мал аж ахуй, газар тариалан, хүнс худалдаа, жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт хийгдсэн онцлох ажлуудын талаар сар бүр товч мэдээлэл бэлтгэн нээлттэй байршуулан ажилласан. Жилийн эцсийн байдлаар ЖДҮ эрхлэгчийн тодорхойлолт авахаар албан бичгээр хандсан нийт 15 ААН-д тодорхойлолтыг олгосон. ЖДҮХС-аас 2022 онд олгох хөнгөлөлттэй зээлийн төслийг 2022 оны 6 дугаар сарын 6-ны өдрөөс эхлэн цахим ситемээр дамжуулан 7 хоногийн 24 цагийн турш хүлээн авсан ба цахим системд зээлийн хүсэлт гаргаж төслөө илгээсэн аж ахуйн нэгж нь зээлийн хүсэлтийн явцаа цахимаар хянах боломжтой давуу талуудыг бий болгосон. МУ-ын Засгийн газраас 3 хувийн хүүтэй 24 сарын хугацаатай зээл олгохоор шийдвэрлэсний дагуу зээлийн талаарх мэдээллийг АЗДТГ, ХХААГ, 14 сумын цахим хуудсаар болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр (DTV) танилцуулан давхардсан тоогоор нийт 14864 иргэн, хоршоо, ААН-д хүргэсэн.</p> <div style="display: flex; justify-content: space-around; align-items: center;">   </div>	100






1.2.	<p>Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;</p>	<p>Байгууллагын веб хуудаст болон мэдээллийн самбарт байгууллагын хаяг байршил, харилцах утас, шуудангийн хаяг, өргөдөл, гомдол хүсэлт хүлээн авах, олон нийттэй харилцах ажилтны мэдээлэл, нийгмийн сүлжээний хаягийн мэдээллийг цахим хуудасны ил тод байдал цэсний өргөдөл хэсэгт оруулсан. Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд хөдөө аж ахуйн төсөл хөтөлбөр, зээлийн мэдээлэл, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, мал аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны заавар сургалт зөвлөгөөний талаар видео болон зурагт текстэн мэдээллийг бэлтгэж байгууллагын цахим хуудсанд 129 мэдээ, нийгмийн сүлжээний Фэйсбүүк хуудсанд 291 мэдээ, Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын цахим хуудсанд 18 мэдээ, сумдын хөдөө аж ахуйн тасагт 28, нийт 466 мэдээллийг бэлтгэж оруулсан.</p>	100



1.3.	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайланд гүйцэтгэлийн аудит орж зөрчилгүй дүгнэлт гарсан ба 1 зөвлөмж, 1 албан шаардлага гарсны дагуу хяналтанд авч төлөвлөгөө гарган холбогдох байгууллагад бичиг баримтыг бүрдүүлэн хүргүүлж зөрчил дутагдлыг 100 хувь арилгаж ажилласан. 2021 онд тус байгууллагын дотоод үйл ажиллагаанд аудит хийгдээгүй, Санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлтийг байгууллагын санхүүгийн мэдээллийн самбарт ил тод байршуулсан.	100
1.4.	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Хүнс хөдөө аж ахуйн салбар хууль 10, ерөнхийлөгчийн зарлиг 2, засгийн газрын тогтоол 22, засгийн газрын хуралдааны тэмдэглэл 8, засгийн газрын албан даалгавар 3 үйл ажиллагаандаа мөрдөж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	80
1.5.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	Хүнс хөдөө аж ахуйн салбарын бодлогын арга хэмжээг Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө, АЗДҮАХ-т тусгуулан үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллаж тайланд хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ хийж хугацаанд нь тайлагнасан ба АЗДҮАХ-ийн 35 арга хэмжээний биелэлт 96.2%, Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний 27 арга хэмжээний биелэлт 97.3%-тай дүгнэгдсэн. Үндэсний хөтөлбөрийн хүрээнд орон нутагт батлагдсан 4 дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргаж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн (Хүнсний ногоо-90.0%, Жимс жимсгэнэ-84.1%, Иргэн бүр санаачлагч-Өрх бүр үйлдвэрлэгч – 93.46%, Монгол малчин-88.85%) үнэлүүлсэн. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 13 арга хэмжээг 90%, 6 үндэсний хөтөлбөрийн 60 арга хэмжээг 93.24%-тай хэрэгжүүлэн ажиллаж “Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан”-д гүйцэтгэлийг хугацаанд нь тайлагнасан.	90
1.6.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Хүнс хөдөө аж ахуйн салбар хууль 10, ерөнхийлөгчийн зарлиг 2, засгийн газрын тогтоол 22, засгийн газрын хуралдааны тэмдэглэл 8, засгийн газрын албан даалгавар 3 үйл ажиллагаандаа мөрдөж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомж, МУЗГ-аас зарлагдсан төсөл хөтөлбөр, зээлийн мэдээллийн талаар видео болон зурагт текстэн мэдээллийг бэлтгэж байгууллагын цахим хуудсанд 61 мэдээ, нийгмийн сүлжээний Фэйсбүүк хуудсанд 281 мэдээ, Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын цахим хуудсанд 8 мэдээ, сумдын хөдөө аж ахуйн тасагт 28, нийт 309 мэдээллийг бэлтгэж оруулсан.	100
1.7.	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/ийн нэр, өөрийн нэр, албаны харилц	Тус байгууллагаас ТАЗ-ын Дорноговь аймаг дахь салбар зөвлөлд жилийн эцсийн байдлаар төрийн захиргааны сул 2 орон тооны захиалгыг хүргүүлж тусгай шалгалтыг зарлуулсан. Сул орон тооны албан тушаалын тодорхойлолтыг ТАЗ-д хүргүүлснээр тусгай шалгалтад бүртгүүлэхээр www.csc.gov.mn сайтад хандсан иргэдэд тухайн албан тушаалын тодорхойлолтыг нээлттэй, ил тод байлгах нөхцөлийг	100



	<p>ах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;</p>	<p>бүрдүүлсэн. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангаж do.mofa.gov.mn веб хуудас болон dornogovi.gov.mn сайт, мэдээллийн самбарт албан хаагчдын албан тушаал, и-мэйл хаяг, холбоо барих утас зэрэг мэдээ, мэдээллийг шинэчлэн олон нийтэд ил тод байршуулан ажилласан.</p>	
<p>1.8.</p>	<p>Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;</p>	<p>Тус байгууллагад 2022 оны жилийн эцсийн байдлаар 16 иргэнээс өргөдөл ирснийг бүртгэн хүлээн авч хулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн. Үүнд: Ажлаас чөлөөлөх тухай өргөдөл-3,ажилд орох тухай өргөдөл-9, хүүхэд асрах чөлөө олгох тухай-2, тусламж хүсэх тухай-1, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай хүсэлт-1. Өргөдөл, гомдлын тайланг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Мөн жилийн эцсийн байдлаар ЖДҮ эрхлэгчийн тодорхойлолт авахаар албан бичгээр хандсан нийт 15 ААН-ийн хүсэлтийн дагуу тодорхойлолтыг түргэн шуурхай олгож үйлчилсэн.</p>	<p>100</p>
<p>1.9.</p>	<p>Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;</p>	<p>Мал аж ахуй, газар тариалан, хүнс, худалдаа, жижиг дунд үйлдвэрийн салбарын статистик мэдээллийг сар бүр шинэчлэн байгууллагын гадна мэдээллийн самбарт нээлттэй байршуулж ажилласан. Мөн статистикийн хэлтсийн цахим хуудаст мал аж ахуй, газар тариалангийн салбарын сар бүрийн статистик мэдээлэл тогтмол байршуулсан.</p>	<p>100</p>
<p>1.10.</p>	<p>Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.</p>	<p>Жилийн эцсийн байдлаар тус байгууллагаас мал аж ахуй, газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр нийт 21 удаагийн танхимын болон цахим сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 1263 иргэнийг, 2 удаагийн туршлага судлах, практик сургалтад 6 хоршооны нийт 12 иргэнийг тус тус хамруулсан. Зохион байгуулахаар төлөвлөсөн арга хэмжээний зар мэдээллийг аймгийн ЗДТГ, сумдын ЗДТГ болон байгууллагын цахим хуудсаар нээлттэй ил тод байршуулан ажилласан.</p> 	<p>100</p>


			
Хэсгийн дундаж хувь:			97
Хоёр.Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
2.1.	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	<p>Төрийн албаны сул орон тооны тусгай шалгалтын зар мэдээллийг байгууллагын цахим хуудаст байрлуулж олон нийтэд нээлттэй зарласан. Тус байгууллагад 2022 онд гарсан сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлд хүргүүлж төрийн албаны тусгай шалгалтыг зарлуулан нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Төрийн үйлчилгээний албан хаагчдыг нөхөн томилоход хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй иргэдээс сонгон авч ажиллуулж байна. 2022 онд жирэмсний чөлөөтэй 1 албан хаагчийн сул орон тоог нийтэд зарлан нөхөн томилсон.</p> 	100
2.2.	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	<p>Төрийн захиргааны албан хаагчийг томилохдоо Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан нийтлэг шаардлага болон 23 дугаар зүйлд заасан тусгай шаардлагыг хангасан иргэнийг аймгийн ТАЗ-ийн нэр дэвшүүлэх тухай тогтоолын дагуу томилж ажилласан. Сул албан тушаалд тавигдах шаардлагыг ТАЗ-д хүргүүлснээр ажилд орохыг хүссэн, тухайн албан тушаалд шалгалт өгөх</p>	100

		иргэн тавигдах шаардлага, сонгон шалгаруулах журамтай танилцах боломжийг нээлттэй бүрдүүлсэн. Жилийн эцсийн байдлаар тус байгууллагад сул орон тоог нөхөх төрийн албаны тусгай шалгалт 3 удаа зарлагдаж сонгон шалгаруулалтын зар мэдээллийг байгууллагын цахим хуудсанд ил тод байршуулж олон нийтэд мэдээлснээр сул орон тоог бүрдүүлэн ажиллаж байна.	
2.3.	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	<p>Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2021 оны А/30 дугаар тушаалаар батлагдсан Байгууллагын ёс зүйн хороо нь албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг албан хаагчдад танилцуулан байгууллагын веб хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. Тайлант онд ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй.</p> 	100
2.4.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2014 оны 22 тоот тогтоолын хавсралт “Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг үнэлж дүгнэх журам”-ийг байгууллагын do.mofa.gov.mn веб хуудсанд байршуулсан. Журмыг байршуулсанаар хэрэглэгчдэд нээлтэй уншиж, судлах боломжыг бүрдүүлсэн.	90
2.5.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	<p>Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангаж do.mofa.gov.mn веб хуудас болон dornogovi.gov.mn сайтад байгууллагын бүтэц, санал хүсэлт, өргөдөл гомдол хүлээн авах албан хаагчийн овог нэр, холбоо барих утас, и-мэйл хаяг, өргөдөл хүлээн авах цагийн мэдээлэл болон албан хаагчдын албан тушаал, и-мэйл хаяг, холбоо барих утас зэрэг мэдээ, мэдээллийг шинэчлэн олон нийтэд ил тод байршуулан ажилласан.</p> <p>Жилийн эцсийн байдлаар тус байгууллагад сул орон тоог нөхөх төрийн албаны тусгай шалгалт 3 удаа зарлагдаж сонгон шалгаруулалтын зар мэдээллийг байгууллагын цахим хуудсанд ил тод байршуулж олон нийтэд мэдээлснээр сул орон тоог бүрдүүлэн ажиллаж байна. Төрийн үйлчилгээний албан хаагчдыг нөхөн томилоход хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй иргэдээс сонгон авч ажиллуулж байна. 2022 онд жирэмсний чөлөөтэй 1 албан хаагчийн сул орон тоог нийтэд зарлан нөхөн томилсон.</p>	100

		 <p>ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР ДОРНОГОВЬ АЙМАГ</p> <p>Бүтэц зохион байгуулалт</p> <p>БҮТЭЦИЙН НЭГЖ</p> <ul style="list-style-type: none"> Захиргаа, Аж ахуйн алба Үйлдвэр, Худалдаа үйлчилгээний алба Мал үржлийн алба <p>Захиргаа, Аж ахуйн алба</p> <p>Төрийн албан хаагч</p> <table border="1"> <thead> <tr> <th>#</th> <th>Эцэг / эхийн нэр, Өөрийн нэр</th> <th>Албан тушаал</th> <th>Холбоо барих</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1.</td> <td>Жүдэр НАРАНБОЛД</td> <td>Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга</td> <td>99053299</td> </tr> <tr> <td>2.</td> <td>Дугаржав ОТГОНБУЛАГ</td> <td>Нагтман бодогч</td> <td>99907059</td> </tr> <tr> <td>3.</td> <td>Энхтүвшэн ЗОЛЖАРГАЛ</td> <td>Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн</td> <td>91100719</td> </tr> <tr> <td>4.</td> <td>Батсайхан АЛТАН-БИМЭГ</td> <td>Хүний нөөц, сургалт, сурталчилгаа, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн</td> <td>95094909</td> </tr> <tr> <td>5.</td> <td>Уранчимэг АНСАЛМАА</td> <td>Техник хэрэгсэл, програми, сүлжээ, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн</td> <td>96733009</td> </tr> <tr> <td>6.</td> <td>Од-Эрдэнэ АДЪЯА</td> <td>Аж ахуйн илрэл</td> <td>99296864</td> </tr> </tbody> </table>	#	Эцэг / эхийн нэр, Өөрийн нэр	Албан тушаал	Холбоо барих	1.	Жүдэр НАРАНБОЛД	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга	99053299	2.	Дугаржав ОТГОНБУЛАГ	Нагтман бодогч	99907059	3.	Энхтүвшэн ЗОЛЖАРГАЛ	Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн	91100719	4.	Батсайхан АЛТАН-БИМЭГ	Хүний нөөц, сургалт, сурталчилгаа, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн	95094909	5.	Уранчимэг АНСАЛМАА	Техник хэрэгсэл, програми, сүлжээ, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	96733009	6.	Од-Эрдэнэ АДЪЯА	Аж ахуйн илрэл	99296864	
#	Эцэг / эхийн нэр, Өөрийн нэр	Албан тушаал	Холбоо барих																												
1.	Жүдэр НАРАНБОЛД	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга	99053299																												
2.	Дугаржав ОТГОНБУЛАГ	Нагтман бодогч	99907059																												
3.	Энхтүвшэн ЗОЛЖАРГАЛ	Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн	91100719																												
4.	Батсайхан АЛТАН-БИМЭГ	Хүний нөөц, сургалт, сурталчилгаа, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн	95094909																												
5.	Уранчимэг АНСАЛМАА	Техник хэрэгсэл, програми, сүлжээ, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	96733009																												
6.	Од-Эрдэнэ АДЪЯА	Аж ахуйн илрэл	99296864																												
2.6.	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	<p>Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 100 дугаар тушаалын дагуу төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх аргачлалыг албан хаагчдад танилцуулан do.mofa.gov.mn цахим хуудас, https://profile.igovernment.mn/ мэдээллийн цахим санд байршуулсан. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг plan.igovernment.mn цахим хуудсанд сар, улирал, хагас жилээр тайлагнаж үнэлгээг баталгаажуулсан.</p> <p>ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ САН</p> <div style="display: flex; justify-content: space-around;"> <div data-bbox="714 1018 1081 1209">  <p>БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ - Гүйцэтгэлийн удирдлага -</p> </div> <div data-bbox="1113 1018 1480 1209">  <p>ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН НЭГЖИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ - Гүйцэтгэлийн удирдлага -</p> </div> <div data-bbox="1512 1018 1879 1209">  <p>ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ - Гүйцэтгэлийн удирдлага -</p> </div> </div> <div style="display: flex; justify-content: space-around; margin-top: 20px;"> <div data-bbox="714 1238 1081 1361">  </div> </div>	100																												
Хэсгийн дундаж хувь:		98																													
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх																															

мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
3.1.	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	<p>2022 онд санхүүгийн үйл ажиллагаанд төсвийн хэмнэлтийн хууль болон бусад холбогдолтой хууль тогтоомж, дүрэм журам стандартыг мөрдлөгө болгон төсөв зардлыг хөтөлбөр, арга хэмжээ, ангилал зориулалтын дагуу зарцуулж санхүүгийн зөрчил дутагдалгүй ажилласан. 2023 оны төсвийн төсөөллийг боловсруулан гаргаж mofa.opengov.mn цахим хуудаст байршуулан албан бичгээр хүргүүлсэн</p> <p>Өмнөх оны болон тайлант оны сар бүрийн төсийн гүйцэтгэлийн мэдээг http://www.do.mofa.gov.mn/ цахим хаягт тухай бүр тогтмол байршуулсан.</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div>	100
3.2.	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	<p>1,2,3 дугаар улирлын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гарган албан бичгээр ХХААХҮ-ийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн. Байгууллагын цахим хуудасны ил тод цэсний төсөв санхүү дэд цэсэнд бүтэн жилийн төсөв, 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн тайлан, 1-11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг байршуулсан.</p>	100

			
3.3.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	<p>Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайланд хийсэн шалгалтаар зөрчилгүй дүгнэлт авсан. Аудитын дүгнэлтийг санхүүгийн мэдээллийн самбар, байгууллагын http://www.do.mofa.gov.mn/ цахим хуудаст ил тод байршуулсан.</p> 	100
3.5.	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	Сар бүр шилэн дансанд төсвийн гүйцэтгэлийн мэдээг оруулж хэвшсэнээс гадна хэмнэлт, хэтрэлтийн шалтгааныг бичиж оруулсан.	100

			
3.7.	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	Жилийн эцсийн байдлаар цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий 386537.4 мянган төгрөгийн орлого, 0 зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт сар бүр шилэн дансанд оруулж ирсэн.	100
3.8.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	Жилийн эцсийн байдлаар төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой байгууллагын даргын А тушаал 25-ыг ил тод байршуулсан	100
3.9.	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	Шилэн дансанд сар, улирал бүр санхүүтэй холбоотой мэдээллийг бүрэн оруулж ирсэн. 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмж, албан шаардлагын дагуу төлөвлөгөө гарган хэрэгжилтийн тайланг байршуулсан. Мөн албан бичгээр ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-т 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 121 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	100
3.15.	Хууль тогтоомжид заасан бусад.	Жилийн эцсийн байдлаар байгууллагын санхүүгийн мэдээллийн самбарт сар бүр санхүүтэй холбоотой мэдээллийг шинэчлэн байршуулж, мөн шилэн дансанд оруулж ил тод байдлыг хангаж ажилласан.	100
Хэсгийн дундаж хувь:			100

Дөрөв.Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
4.1.	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	Жилийн эцсийн байдлаар үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл гараагүй.	100
Хэсгийн дундаж хувь:			100
Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
5.1.	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж бол он захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;	“Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулах, отор нүүдэл зохицуулах” журмыг орон нутагтаа гарган хэрэгжүүлэх, өвөлжилт, хаваржилтад эртнээс бэлтгэн ажиллах шаардлагатай тухай сумдад албан бичиг хүргүүлж, Шинээр гаргах журамд санаа өгөх зорилгоор журмын төслийг хавсралтаар хүргүүлсний дагуу малчдаас санал авах ажлыг зохион байгуулсан.	100
5.2.	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	<p>Дэлгэрэх сумын нутгийн улаан ямааг омгоор баталгаажуулах судалгаа шинжилгээний ажлыг 2010 оноос эхлүүлж 2019 оны 03 сарын 07 –ны өдөр ХХААХҮЯ –ны сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ХХААХҮ-ийн сайдын А-61 дүгээр тушаалаар бие даасан “Дэлгэрэхийн улаан” омгоор баталгаажуулж, Монгол улсад шинээр зохион бүтээсэн мал, амьтны улсын бүртгэлд 2019 оны 03 дугаар сарын 12 –ны өдөр бүртгэгдэж Я-11 дугаартай гэрчилгээ авсан.</p> <p>Мөн Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 58 дугаар тогтоолоор “Дорноговийн хонины мах хөтөлбөр”-ийг батлан Мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран 2020-2021 онд судалгааны ажлыг хийж гүйцэтгэснээр 2022 онд Оюуны өмчийн газраар баталгаажуулсан “Зохиогчийн эрхийн гэрчилгээг” хүлээн авсан.</p> <p>“Дэлгэрэхийн улаан” омгийн үүлдэрлэг байдал, Дорноговийн хонины махны ашиг шимийн талаар гарын авлага, танилцуулга самбарыг бэлтгэн Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Намрын ногоон өдрүүд 2022” үзэсгэлэн худалдаа, 14 суманд зохион байгуулсан “Иргэн төвтэй – Төрийн үйлчилгээ” нэгдсэн өдөрлөгийн үеэр иргэд, олон нийтэд сурталчлан таниулснаас гадна, байгууллагын гадна мэдээллийн самбарт ил тод байршуулан ажилласан.</p>	100
5.4.	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Тус байгууллага нь 1665 м2 хэмжээтэй 26640,0 мянган төгрөгийн үнэтэй, 2257 м2 хэмжээтэй 36112,0 мянган төгрөгийн үнэтэй 2 газар бүртгэлтэй.	100

5.5.	<p>Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь</p> <p>хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;</p>	<p>Хүнс, хөдөө аж ахуйн газар нь төрийн 100 хувийн оролцоотой. Дорноговь аймгийн Сайншанд сумын 2 дугаар багийн Эрүүл мэндийн гудамж байрладаг. Өөрийн дүрмийн сан, үйл ажиллагааны чиглэлтэй улирал бүр санхүүгийн тайлан гаргадаг. Жилийн эцсийн байдлаар 15240,1 мянган төгрөгийн татвар төлөөд байна.</p>	100
5.8.	<p>Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;</p>	<p>Тус аймагт тариалангийн талбайн хөрсний үржил шимийг сайжруулах судалгааны ажил 100 хувь хийгдсэн. Судалгаанд 13 сумын 2000 гаруй га талбайг хамруулж, 1900 га талбайд усалгаатай тариалан эрхлэх боломжтой болох нь тогтоогдсон. Хөрсний шинжилгээний дүн мэдээ, зөвлөмжийг тариаланчдад хүргүүлсэн.</p>	100
5.11.	<p>Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;</p>	<p>Байгууллагын зорилт, байгууллагын түүх, байгууллагын бүтэц, хүний нөөцийн нэр, алба хэлтсийн зохион байгуулалт, албан хаагчдын овог нэр, албан тушаал, холбоо барих утасны дугаар, өргөдөл, гомдол хүлээн авах албан хаагчийн мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.</p>	100
5.12.	<p>Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;</p>	<p>Жилийн эцсийн байдлаар төрийн захиргааны 1, төрийн үйлчилгээний 1 албан хаагчийг мэргэшүүлэх 14-26 хоногийн сургалтад хамруулж 400.0 мянган төгрөгийн сургалтын төлбөрийг байгууллагаас шийдвэрлэж мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэх нөхцлийг бүрдүүлж өгсөн. Байгууллагын зардлаар суралцсан албан хаагч нь албан үүргээ бүрэн хэрэгжүүлэн жилийн эцсийн ажлын үнэлгээгээр хангалттай үнэлгээ авсан.</p>	100
5.13.	<p>Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.</p>	<p>Мэдээллийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд хөдөө аж ахуйн үйл ажиллагааны дүрэм, дотоод журам, үйл ажиллагааны тайлан, хөдөө аж ахуйн салбарын Монгол улсын, УИХ, Сайдын тогтоол, шийдвэр, хууль, төсөл хөтөлбөр, хоршоо хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрийн зээлийн мэдээлэл, төсөл хөтөлбөрт хамрагдахад шаардлагатай баримт бичгийн жагсаалт, мал аж ахуй, жижиг дунд</p>	100

		<p>үйлдвэрлэл, хоршооны заавар сургалт зөвлөгөөний талаар видео болон зурагт текстэн мэдээллийг бэлтгэж байгууллагын цахим хуудсанд 61 мэдээ, нийгмийн сүлжээний Фэйсбүүк хуудсанд 212 мэдээ, Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын цахим хуудсанд 8 мэдээ, 14 сумдын хөдөө аж ахуйн тасагт 2 удаа тус тус 28 мэдээлэл, нийгмийн сүлжээний хуудас, байгууллагын цахим хуудсанд давхар оруулж нийтдээ 321 мэдээлэл бэлтгэн оруулсан. Байгууллагын гадна мэдээллийн самбарт мал аж ахуй, газар тариалан, хүнс худалдаа, жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт хийгдсэн онцлох ажлуудын талаар сар бүр товч мэдээлэл 5 удаа бэлтгэн нээлттэй байршуулан ажилласан. Цахим хуудасны төрийн үйлчилгээ хэсэгт 4 мэдээлэл, өргөдөл гомдол хүлээн авах хэсгийг цахим хуудсандаа ажиллуулж иргэд, хуулийн этгээдэд өргөдөл гомдол мэдүүлэх боломжийг хангасан.</p>	
Хэсгийн дундаж хувь:		100	
Хэрэгжилтийн дундаж хувь:		99	